



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 02 сарын 22 өдөр

Дугаар А/15

Улаанбаатар хот

“Бүргэдийн баяр” арга хэмжээнд
дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 03/08 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 1.4.9, 2017 оны 01/19 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн Эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн 1.55, Нийслэлийн Засаг даргын 2018 оны А/152 дугаар захирамж, Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрмийн 2.5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх, жуулчны улирлын хугацааг уртасгах зорилгоор зохион байгуулах “Бүргэдийн баяр” арга хэмжээнд дэмжлэг үзүүлж ажиллахыг Бодлого, төлөвлөлтийн хэлтэс /Б.Тулгаа/-т үүрэг болгосугай.

2. Тус арга хэмжээнд шаардагдах, энэ тушаалын хавсралтад заасан 10900000 /арван сая есөн зуун мянган/ төгрөгийг холбогдох зардлаас тооцож гаргахыг Ахлах нягтлан бодогч /Б.Батбаатар/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА *D. Balin* Д.БАТСҮХ



1150500047

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2018 оны 02 сарын 22
өдрийн А.5 дугаар тушаалын хавсралт



**“БҮРГЭДИЙН БАЯР” АРГА ХЭМЖЭЭНД
ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ЗАРДЛЫН ТӨСӨВ**

2018 оны 02 дугаар сарын 22

Улаанбаатар хот

№	Зардлын зүйл	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Бүргэдийн баярт оролцох бүргэдчдийн Баян-Өлгий-Улаанбаатар, Улаанбаатар-Баян-Өлгийн чиглэлийн онгоцны зардал /хоёр талдаа/	25 хүн	436 000	10 900 000
Нийт дүн			10 900 000	

--oo0oo--